

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх Ухаан, Дээд  
Боловсролын Хүрээлэнгийн Хэл Зохиол Судлах Газрын  
цуврал бичиг

## ХЭЛ ЗОХИОЛ

Тэргүүн боть

Дөрөвдүгээр дэвтэр

Ш. Барайшир (Улаанбаатар)

МОНГОЛЧ ЭРДЭМТЭН  
Б. Я. ВЛАДИМИРЦОВ




Улаанбаатар  
1960

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх Ухаан, Дээд  
Боловсролын Хүрээлэнгийн Хэл Зохиол Судлах Газрын  
цуврал бичиг

## ХЭЛ ЗОХИОЛ

Тэргүүн боть

Дөрөвдүгээр дэвтэр



**МОНГОЛЧ ЭРДЭМТЭН**  
**Б. Я. ВЛАДИМИРЦОВ**

Шинжлэх Ухаан, Дээд Боловсролын Хүрээлэнгийн  
Эрдэм шинжилгээний хэвлэл

Улаанбаатар

1960



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх Ухаан, Дээд  
Боловсролын Хүрээлэнгийн Хэл Зохиол Судлах Газрын  
цуврал бичиг

## ХЭЛ ЗОХИОЛ

Редактор А. Лувсандэндэв

## Монголч эрдэмтэн Б. Я. Владимирцов (1884-1931)

Борис Яковлевич Владимирцов бол Зөвлөлтийн нэрт монголч эрдэмтдийн нэг бөгөөд түүхч, хэлний шинжлэлч төдийгүй, ардын аман зохиол, утга зохиол, угсаатны зүй зэрэг нийгэмлэгийн шинжлэх ухааны томхон судлалч билээ.

Б. Я. Владимирцов, бүр багаасаа түүхийн ухаанаар оролдохын хамт өөрийн эх орны болон өрнө, дорнын улс үндэстний утга зохиолыг гүнзгий судалж эхэлжээ. Энэ нь түүний хурц оюун билгийг хөгжүүлэн, ирээдүйд том эрдэмтний зэргт хүрэхийн чухал нөхцөл болсон ажээ.

Борис Яковлевич, 20 настайдаа 1904 онд Петербургийн Их сургуулийн дорно дахины хэл судлах салбарт орж 1909 онд төгсчээ. Тэр үед Петербургийн Их сургуулийн дорно дахины хэл судлах салбарыг нэрт монголч эрдэмтэн В. Л. Котвич, А. Д. Руднев зэрэг хүмүүс удирдаж байсны гадна тэнд алдарт эрдэмтэн В. В. Бартольд, Л. Я Штернберг, Л. В. Щерба нар ажиллаж байжээ.

Б. Я. Владимирцов, эрдэм судлалын ажлыг бүр оюутан байх үеэсээ эхэлсэн бөгөөд (Петербургийн Их сургуульд сурч байхдаа) 1907 онд Астраханы хязгаараар халимаг хэл, Баруун Монголын нутгаар аман зохиол, монгол хэл судлах шинжилгээний ажлаар явж байжээ. Дараа нь 1911-1913 онуудад монголын баруун болоод хойд хэсгээр, 1926 онд Хэнтийн орчин газраар тус тус шинжилгээний ажил явуулж, урагшаа манай их хөрш Б.Н.Х.А. Улсын нийслэл Бээжин хүртэл явж байжээ. Академич Владимирцов, энэ мэтээр эрдэм судлалын ажлыг жинхэнэ газар дээр нь биечлэн явуулж байснаар барахгүй, Париж, Лондон зэрэг том том хотоор явж тэндэхийн номын сан, музей зэрэг газрууд дахь монголын холбогдол бүхий ном судлалтай танилцаж байжээ. Жишээ нь: Британийн музейн монголын фондыг судалж байсан байна.

Б. Я. Владимирцов, эрдэм шинжилгээний ажлыг уйгагүй махруун оролддог, бага хугацаанд их зүйлийг бүтээдэг, үнэхээр шинжлэх ухааны үйл хэрэгт амь насаа зориулсан, ямар ч бэрхшээлээс айж сүрддэггүй, ямагт түүнийг даван туулдаг, ёстой бүтээлч эрдэмтэн байжээ. Тийм ч учраас олон талын өргөн мэдлэгтэй болж 1921 онд 37 настайдаа профессор, наймхан жилийн дараа 1929 онд академич болсон ажээ. Их эрдэмтэн нас барахынхаа өмнөхөн үхлүүд хэвтэж байхдаа „Би дахиад 5 жил л амьд явбал өөрийнхөө гол бүтээлийг дуусгачих байсан юм“ гэж итгэл төгс хэлж байжээ. Энэ нь түүний эрдэм судлалын ажил хичнээн их өргөн далайцтай, хичнээн тодорхой зорилготой байсныг харуулж байна. Борис Яковлевич, богино хугацаанд эрдэм шинжилгээний гүн гүнзгий агуулгатай, баялаг материал цуглуулж, түүнийгээ нэгтгэн дүгнэсэн эрдэм судлалын хэд хэдэн том зохиол бичихээр эрчим төгс ажиллаж байсан бөгөөд түүний хэлснээр гол бүтээл гэдэг нь зөвхөн ганц хоёр өгүүлэл байгаагүй нь мэдээж хэргээ. Үүнд, ганцхан жишээ хэлэхэд, Б.Я. Владимирцов, зөвхөн монгол хэлний талаар монгол хэлний авианзүй, үгзүй, өгүүлбэрзүй, утгазүйг багтаасан бүрэн зүй бичих гэж байснаас дөнгөж ганцхан авианзүйг бичээд бусдыг бичиж амжилгүй нас баржээ.

Б. Я. Владимирцов, шинжлэх ухааныг онцгой маягийн ухамсар гэж үзэж, түүнд бүх үйл хэргээ захируулан, түүнийг бүхнээс илүү үнэлдэг байжээ.<sup>1</sup>

Академич Владимирцов, монгол хэлийг гарамгай сурсны гадна өрнө, дорнын нилээд олон хэл мэддэг байжээ.

Бас халимаг хэл сайн мэддэг байсан учир халимагууд урьж өөрийнхөө эх хэл, утга зохиолын тухай лекц уншуулахыг хүсэж байжээ. Энэ бүхэн нь түүний гайхам чадалтай авьяас билигт эрдэмтэн байсныг гэрчлэх билээ. Борис Яковлевичийн анх хэвлүүлсэн бүтээл нь 1909 онд 1908 оны зун Ховд хязгаарын дөрвөдүүдийн дотор ажилласан тухай Б. Я. Владимирцовын тайлан“ гэдэг нэртэй гарчээ. Энэ зохиол хэмжээгээр бага боловч утгаар өргөн, олон талтай бүтээл юм.

Б. Я. Владимирцов, эрдэм шинжилгээний зохиол бичихдээ, жишээнэ ашиглавал зохих, маргашгүй баримтуудыг түшиглэн, товч тодорхой бичдэг, олон үгтэй нуршаа зүйлд дургүй хүн байжээ. Эрдэмтэн Владимирцов, монголын утга зохиол, ардын аман зохиол, монгол хэлийг судлагч төдийгүй,

<sup>1</sup> В.М.Алексеев. Памяти академика Владимирцова, «Вестник Академии Наук СССР», 1931, №8. 16-р талд.

монголын түүх, эдийн засаг, зан заншлыг судлагч байсан бөгөөд өөрийн бүтээлээр монголын судлалыг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлжээ.

Зөвлөлтийн эрдэмтэн Н. П. Шастина, Борис Яковлевичийн дурсгалд зориулсан өгүүлэлдээ, „Б. Я. Владимирцовын эрдэм шинжилгээний үйл ажиллагаа нь шинжлэх ухааны цаашдын хөгжлийн үндсийг тавьж, замыг нээсэн бөгөөд түүгээр эдүгээгийн монголыг судлагчдын бүхэл үеийнхний эрдэм судлалын үйл ажиллагаа замнаж байна гэж бид одоо нэгэнт тэмдэглэж болно“<sup>1</sup> гэжээ.

Борис Яковлевич Владимирцов, Оросын дорно дахины судлалын сонгодог сургуульд хамаарагдах бөгөөд түүний гялалзсан төлөөлөгчдийн нэг юм.

Академич Владимирцов, гарамгай эрдэмтний хувьд, „... Зөвлөлтийн дорно дахины судлалд үнэлж баршгүй хувь нэмэр оруулжээ.“<sup>2</sup>

Тэрээр, өмнөх үеийнхээ монгол хэлний судлалч нарын бараг бүтээгээгүй зүйлийг бүтээж, монголын судлалыг, шинжлэх ухааны уудам талбарт дэвшүүлэн гаргажээ.

Монгол хэлийг эн тэргүүн түүхийн үүднээс харшуулан судалсан хүн бол Б. Я. Владимирцов юм.

Монгол хэл аялгууны түүхийн шийдвэрлэх асуудал академич Владимирцовын эрдэм судлалын сонирхолын төвд үргэлж байсан юм гэж профессор Санжеев зүй ёсоор тэмдэглэсэн билээ.

Их эрдэмтний хэлний шинжлэлийн талаархи хамгийн алдартай бүтээл нь 1929 онд хэвлэгдсэн „Монгол бичгийн хэл, халх аялгууг харшуулсан зүйн бичиг“ гэдэг ном юмаа. Энэ ном монгол хэлний авианзүйн тогтолцооны судлалын суурь нь болсон билээ. Б. Я. Владимирцов, энэ зохиолдоо, монгол бичгийн хэл, ярианы хэл хоёрын хөгжлийн ерөнхий зургийг гаргаж, монгол хэлний урт, хос, балархай эгшигийн бий болсон зам хууль болон эгшиг зохицох ёс хийгээд монгол хэлний дотоодын өвөрмөц хувирал зэргийг баримт сэлтээр нотлон үзүүлжээ.

Б. Я. Владимирцов, дээр дурдсан зохиолдоо, монгол бичгийн хэл, халх аялгуу хоёрыг түүхийн үүднээс харшуулан

<sup>1</sup> «Филология и история монгольских народов» 1958. Москва. (дурдсан номын 3-р тал)

<sup>2</sup> Г.И.Михайлов. Литературоведческие концепции Б.Я.Владимирцова. Мөн номын 41-р талд

шинжилсэн шинжилгээгээ нэгтгэн дүгнэж, тэдгээрийн үүсэл, хөгжил, үе шат, харилцан холбоо зэргийг нарийвчлан тодорхойлоод, монгол бичгийн хэлний гол гол дурсгалын зүйлийг түүхэн дэс дараагаар нь дурджээ. Тэгээд, монгол хэл аялгууг ангилан хувааж, монгол хэлний гарал үүсэл, өөрөөр хэлбэл монгол хэл, алтай язгуурын хэлний төрөл холбооны тухай өгүүлжээ.

Б. Я. Владимирцовын бичсэн нь: „Монгол хэл, алтай язгуурын хэлэнд хамаарагдах бөгөөд алтайн хэлэнд турк, түнгүүс манж хэл орно.

... Монгол хэл, турк, түнгүүс хэлтэй төрөл юм. Учир нь энэ гурван хэл, нэг хэлний алгуур аажим бөгөөд харилцан адилгүй хөгжлийн үр дүнд бий болжээ.

... Монгол, турк, түнгүүс хэлний, авианзүй, үгзүй, өгүүлбэрзүй, үгсийн сангийн талаархи адил төстэй тогтолцоо нь тэдгээр хэлний төрлийн холбоог үзүүлж байна. Гэвч энэ нь ялангуяа эдгээр хэлний үгзүйн онцлогийн талаар улам ч илэрхий юм<sup>1</sup> гэжээ. Академич Владимирцов, Алтайн хэлний онцлогийн тухай хэлэхдээ, их төлөв алтайн хэл буюу монгол, турк, түнгүүс хэлийг дагаварт хэл гэдэг юм.

Учир нь эдгээр хэлний үгийг хувилгахдаа уул үгийн үндсэнд янз бүрийн дагавар залгаж хувилгадаг. Жишээ нь: туркээр: ev «байшин», evler-in «байшингууд», evler-in «байшингуудын» гэх мэт гээд цааш нь хэлэхдээ: Алтайн хэлний үгэнд дагавар залгаж хэлбэрийг нь өөрчлөхөөс гадна бас өөр аргаар өөрчилж болно. Жишээ нь: биеийн төлөөний үг: vi «би», va «бид», \* ti «чи», ta «та нар»\*, i «тэр»\*, a «тэд»<sup>2</sup> гэх мэт гэжээ.

• Эрдэмтэн Владимирцов, монгол хэлний судлалын талаар дээр дурдсан „харшуулсан зүйн бичиг“-ээс гадна хэмжээгээр бага боловч чухал ач холбогдолтой олон зохиол бичсэн юм. Түүний заримаас энд цухас үгүүлбэл: 1916 онд бичсэн «Монгол хэлний захирах төлөвт үгүйсгэх сул үгийн тухай»<sup>3</sup> үгүүлэл байна. Энэ үгүүлэлдээ, халх болон бусад монгол аялгуунд байдаг захирах төлөвийн бутугеi-бiмегei (халх, битгий) гэдэг үгүйсгэх сул үгийг, бу - (байх) гэсэн үйл үгийн

<sup>1</sup> Б. Я. Владимирцов, „Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия“. Введение и фонетика. Ленинград, 1929, 45-65 дугаар тал.

<sup>2</sup> ... харшуулсан зүйн бичиг. 45-46-р тал.

<sup>3</sup> «Известия Российской Академии наук» 1916, 349-358 дугаар тал.

үндсээс үүсэн юм. Монгол бичгийн хэл хийгээд бусад олон монгол аялгуунд байдаг захирах төлөвийн үгүйсгэх сул үг бу-г дээр дурдсан бу(байх) гэсэн үйл үгийн захирах хэлбэр мөн гэжээ.

1924 онд бичсэн «Монгол хэлний одоо цагт үйлт нэрийн үлдэгдэл»<sup>1</sup> гэдэг үгүүлэлдээ: Урьд нэгэн цагт эртний монгол хэлэнд i-гээр төгссөн, одоо цагт үйлт нэр байжээ. Түүний гэрч нь гар гэдэг үйл үгнээс үүссэн гаруi, дару гэдэг үйл үгнээс үүссэн даруi, би+i (бий, байх), (зүйрлэвэл, туркийн ба-р' бий, байна') гэдэгтэй адил үйл үгнээс үүссэн буi,ге (үлгэрлэвэл, туркийн уг-ук-уi'сөнөх, мөхөх, үхэх, устах, үгүй болох' гэдэгтэй адил) үйл үгнээс үүссэн угеi гэх зэрэг тогтонги хэлбэртэй үгс байгаа явдал мөн гэжээ. 1925 онд хэвлүүлсэн «Монгол хэлний хэлзүйн хүйсийн ул мөр»<sup>2</sup> гэдэг зохиолдоо, гчiн—г,чiн,-джин, хан-кен, гуi гэх зэрэг дагавруудыг монгол хэлний эм хүйсийн ул мөр мөн гээд алаг (эр хүйст нэр)-алаг, ч,iн (эм хүйст нэр), гунан (эр хүйст нэр)-гунаджин (эм хүйст нэр), нојап (эр хүйст нэр)-нојахан (эм хүйст нэр), худа (эр хүйст нэр)-худаг,уi (эм хүйст нэр) гэжээ. Тэгээд эгшиг зохицох ёстой холбогдол бүхий ах (эрэгтэй хүн), эх (эмэгтэй хүн) гэх мэт үгсийг цухас тэмдэглэжээ.

Б. Я. Владимирцов, 1911 онд хэвлүүлсэн «Монгол хэлэн дэх турк хэлний зүйл»<sup>3</sup> гэдэг зохиолдоо, «Монгол турк өвөг хэлний тухай асуудлыг энд бүр орхиж, харин одоо хүртэл зохих ёсоор анхаарч үзэжгүй байсан нэг зүйлийг аль болохоор илрүүлэхийг оролдъё.

Би нэг хэлний зүйл нөгөө хэлэнд орох бололцооны тухай, монгол хэлнээс турк хэлэнд, туркээс монгол хэлэнд орсон зүйлийн тухай өгүүлнэ»<sup>4</sup> гэжээ.

Тэгээд зохиогч утгазүй, авианзүйн талаар бүрэн буюу бараг бүрэн тохирох боловч зөвхөн авианы хувьд ялгаатай монгол, турк үгсийн тухай өгүүлжээ. Жишээ нь: кара-хар, темур-төмөр, улус-улс, ард, есен-эрүүл мэнд, сакал-сахал, жил-туркээр јыл, тарі-туркээр тары, тани-туркээр таны гэх мэт гэжээ.Б.Я. Владимирцов, турк хэл, монгол хэлэнд нөлөөлж, түүнээс монголд орсон үгсийн зарим нь одоо хүртэл хадга-

<sup>1</sup> «Доклады Российской Академии наук» 1924. 55-56-р тал.

<sup>2</sup> «Доклады Российской Академии наук» 1925,31-34-р тал.

<sup>3</sup> «Записки восточного отделения Имп. русского археологического общества» 20-р боть, II-III-р дэвтэр, СПб. 1911, 153-184-р тал.

<sup>4</sup> ... турк хэлний зүйл. 156 дугаар тал.

лагдсаар байгаа боловч, зарим нь хуучирч үгүй болсныг тэмдэглээд, туркээр дамжиж монгол хэлэнд орсон үгсийн тухай бичжээ. Жишээ: Судур, уйг. сутур, самгарди sūtra (ном); шүлэг, уйг. слок, самгарди sloka; ном, уйг. ном. согд. ном. грек nomos гэх мэт.

Турк хэлнээс монгол хэлэнд орсон үгсийн зарим нь олж мэдэхэд хялбархан боловч зарим нь үнэхээр бэрхтэй бөгөөд авианзүйн задлан шинжлэх аргаар тодорхойлох нөхцөлгүй ч тохиолдол бий. Туркээс монголд орсон үгс үгзүй, утгазүйн талаар ихээхэн онцлогтой юм. Жишээ нь: кесег (хэсэг), болуг (бүлэг), коруг (хөрөг, тајаг таяг), біліг (билиг) гэх зэрэг үгсийг монгол хэлзүйн үүднээс авч үзэхэд нилээд төвөгтэй атал, турк хэлзүйн үүднээс үзвэл, кес (туркээр хэсэглэх, огтлох), бол (хуваах, ангилах) кор (үзэх, харах) таја (тулах, түших) біл (мэдэх, ойлгох) гэсэн үйл үгийн үндсэнд -г дагавар залгаж үүссэн үгс гэдэг нь хялбархан мэдэгдэнэ. Туркээс монгол хэлэнд зөвхөн үгсийн сангийн зүйл орсон бус, бас үгзүйн зүйл орсон юм гээд монголын амьд аялгуунд бараг байдаггүй, нөхцөл үйлийн хэлбэр рун: жишээ: огулерун. ра: жишээ абура гэх мэт нь турк гаралтай юм гэжээ. Мөн турк хэлний үгзүйн зүйл миш-миш, зэрэг хэлбэр ойрдын аялгуунд байдаг. Жишээ нь: ца шалдрн, бол-миш банá, цай шингэн болж байна, Ун, шимиш болджá (уншмар болжээ) гэх мэт. Энэхүү миш гэдэг хэлбэр, орчин цагийн турк хэл, эртний уйгур, дундад азийн бичиг, орхон-енисейн дурсгал зэрэгт нилээд тодорхой үзэгддэг ажээ. Борис Яковлевичийн санаачлага, шууд удирдлагаар монгол, буриад, ойрдын аман зохиолын үнэтэй материал хуримтлагджээ. Б. Я. Владимирцовын, монголын утга зохиолын талаархи том бүтээлд юуны урьд 1921 онд хэвлэгдсэн „Банзадандарын үлгэрийн монгол цоморлиг“, 1923 онд хэвлэгдсэн „Монгол, ойрдын баатарлагийн тууль“ зэрэг бүтээл орно. Эдгээр бүтээл хэзээ язаанаас манай ард түмний дотночлон үздэг аугаа их Энэтхэгийн ард түмний соёл, утга зохиолтой танилцуулах төдийгүй, эцэг өвгөдийн үеэс уламжлагдан ирсэн монгол үндсэний баатарлагийн туульсыг өргөн дэлгэрүүлэх ач холбогдолтой нь маргаангүй биээ.

Б. Я. Владимирцовын бичсэн, монгол хэлний хэлзүйн элдэр үзэгдэл, үгсийн бүрэлдэхүүний талаархи өгүүлэлүүд болон монголын түүх, утга зохиол, зан заншлын холбогдолтой бусад олон бүтээл нь манай эх орны түүх, утга зохиол, хэл аялгуу, эдийн засаг, зан заншлыг судлахад чухал материал болсоор байна. Үүнд: „Халхын Цогт Тайжийн хадан дээрх

бичээс“ „Төвөд-монгол толийн тухай“ „Монголын утга зохиол“ „Дэрвөдийн ноёдын гарлын тухай домог“ „Монгол Төвөд дахь буддизм“ „Монголчуудын зан заншлын зарим зүйлээс. I. Архи. II. Тамхи“ „Турк угсаат хотон нар“ „Чингис хаан“, «Баруун Монголын хутгалдмал хоёр хэлний тухай», «Монгол турк өвөг хэлний эгшиглэх ёсын зүйлээс», «Монгол ардын уран зохиолын дээж», «Монгол Данжуур», «Монгол хэлний олон тооны нэг дагаврын тухай», «13-р зууны монголын олон улсын цагаан толгой» гэх зэрэг бүтээлийг жишээ болгон дурдаж болно.

Б. Я. Владимирцов, монголын судлалын талаар хойшид улам их зүйлийг бүтээхээр бэлтгэж байсан боловч эрдэм шинжилгээний ажлынхаа ид өрнөлтийн үед нас баржээ.

Эрдэмтэн Владимирцов, 1931 онд ийнхүү зуурдаар ертөнцийн мөнх бусыг үзэж, Зөвлөлтийн болон дэлхий дахины шинжлэх ухаанд асар их гарз тохиолдсон боловч, богинохон хугацаанд түүний бүтээсэн гайхамшигт бүтээл дэвшилт хүн төрөлхтний соёл, шинжлэх ухааны санд үлэмж хувь нэмэр болсоор байна. Зөвлөлтийн монголч эрдэмтэн Г. И. Михайлов „БЯ Владимирцовын утга зохиол судлалын чиглэл“ гэдэг үгүүлэлдээ: Б. Я. Владимирцовын бүтээл, монголыг судлагчдын шинэ сургууль бүрэлдэн бий болох боломж нээж, түүний анхны шилдэг алхмыг хийжээ<sup>1</sup> гэсэн нь түмэн зүй билээ. Эрдэмтэн Владимирцов, ард түмний оюун билиг хүч чадлыг гүнзгий ухамсарлаж, соёлын өв, шинжлэх ухааны дурсгалт зүйлийг өндөр үнэлдэг хүн байжээ. Энэ нь одоогоос 30 шахам жилийн өмнө бичсэн „Монголын нийгэмлэгийн байгуулал“ гэдэг томоохон бүтээлдээ „Дундад эртний үед олон түүх судрын хүмүүсийг монголчуудын адил сонирхуулан анхааруулсан улс нэг ч үгүй гэж болох ахул «Нууц товчоо»-ны адил үнэн бодит амьдралыг яруу тодоор илтгэн үзүүлсэн дурсгалыг нэг ч нүүдэлчин улс үлдээсэнгүйг тэмдэглэх хэрэгтэй» гэж бичсэнээс илэрхий билээ. Борис Яковлевичийн бичсэн жинхэнэ түүхийн зохиол гэвэл, дээр дурдсан „Монголын нийгэмлэгийн байгуулал“, „Чингис хаан“, „Монгол, Төвөд дэх буддизм “зэрэг бүтээл болно.

Эдгээр бүтээлийн дотроос түүний нас барсны дараа 1934 онд хэвлэгдсэн „Монголын нийгэмлэгийн байгуулал“ гэдэг ном, түүхийн хувьд онцгой ач холбогдолтой билээ. Энэ нь түүний

<sup>1</sup> Г. И. Михайлов. Литературоведческие концепции Б.В. Владимирцова „Филология и история монгольских народов“ гэдэг номын 58 р талд.

сүүлчийн шилдэг зохиол юм. Түүнд зохиогч, түүхт процессыг ойлгох талаар материалист байранд шилжиж, марксизм-ленинизмын үзэл санааны нөлөөгөөр, монголчуудын нийгмийн харьцааг шинээр ойлгож сэтгэхийг оролджээ.

Энэ зохиол, ач холбогдлоороо тэр үеийн монголын судлалын хүрээнээс халин гарч, нүүдлийн феодализмын үе дэх нийгмийн түүхийн ерэнхий шугамыг гэрэлтүүлэн тодорхойлжээ. Гэвч Б. Я. Владимирцов 12-р зууны монголын феодализмын хөгжилтийг хэт үнэлж, тэр үеийн монголын нийгмийн үйлдвэрлэлийн ноёрхох арга нь феодализмын үйлдвэрлэлийн хярицаа байжээ гэсэн нь үнэн байдалд хараахан тохирохгүй бөгөөд учир нь тэр үед монгол, феодализмын харьцаанд шилжих шилжилтийн шатанд байжээ. Тэгэвч энэ нь уул зохиолын түүхэн ач холбогдлыг үгүйсгэж чада хгүй юмаа. Орос, зөвлөлтийн болон гадаадын эрдэмтнүүд эрт дээр үеэс манай эх орны байгаль, эдийн засаг, газар зүй, түүх, утга зохиол, хэл, зан заншил зэргийг сонирхон судалсаар ирсэн билээ. Үүнд, ялангуяа монгол хэл, зохиолыг судлах талаар дэлхнйд алдаршсан Орос, Зөвлөлтийн нэрт эрдэмтэн А. А. Бобровников, Я. Шмидт, А. М. Позднеев, О. Ковалевский, К. Голстунский, А. С. Козин, Г. Д. Санжеев, Финляндын эрдэмтэн Г. И. Рамстедт, Польшийн эрдэмтэн В. Л. Котвич, Мажар Ард Улсын эрдэмтэн Л. Лигети нарын зэрэг олон эрдэмтнийг нэрлэж болно. Эдний дотор монголч их эрдэмтэн Б. Я. Владимирцов маш хүндтэй суурийг эзлэх бөгөөд тэр нь зөвхөн эрдэмтэн төдийгүй бас өдий төдий хүнийг эрдэм шинжилгээний ажилд сургаж, шинжлэх ухааны том зүтгэлтэн болтол нь хүмүүжүүлсэн алдарт багш сурган хүмүүжүүлэгч байжээ. Түүний хүмүүжүүлсэн шавь нарын дотроос эдүгээ эрдэм шинжилгээний ажил дээр үр бүтээлтэй ажиллаж байгаа Зөвлөлтийн монголч эрдэмтэн доктор, профессор Г. Д. Санжеев, Т. А. Бертагасев, дэд эрдэмтэн Г. И. Михайлов нарын зэрэг эрдэмтнийг дурдаж болно. Академич Владимирцов бол өөрийн бүх үйл ажиллагааг эх орныхоо соёл, шинжлэх ухааныг хөгжүүлэхэд зориулснаар барахгүй бас бусад орны ялангуяа дорно дахины хэл, түүх, утга зохиолыг судлахад онц их хүч чармайлт гаргасан хүн юмаа. Зөвлөлтийн эрдэмтэн профессор Г. Д. Санжеев „Монгол хэлнүүдийн харшуулсан зүйн бичиг“ гэдэг номынхоо оршилд, Б. Я. Владимирцовын тухай бичихдээ: „Манай эх орны монголын судлалын бахархал болсон академич Б. Я. Владимирцовын бүтээл юу ч өмнө бидний ажилд онцгой ач холбогдолтой нь мэдээжийн хэрэг“ гэж түүний гандан бууршгүй эрхэм бүтээлийг зүй ёсоор үнэлжээ.

Монголч эрдэмтэн Б. Я. Владимирцовын бүтээл, манай эх орны соёл, шинжлэх ухааны хөгжилтөнд үлэмж хувь нэмэр болохоор барахгүй, дэлхий дахины монголын судлалд үнэлж баршгүй ховор өв болон үлдэж, түүгээр монголыг судлагчдын бүхэл үе хүмүүжсээр байна. Академич Владимирцов, эрдэм шинжилгээний 70 шахам зохиол хэвлүүлсэн бөгөөд түүний нилээд хэсэг нь өрнө, дорнын олон хэлэнд орчуулагджээ.

Зөвлөлтийн ард түмний бахархал болсон гарамгай монголч эрдэмтэн, академич Б. Я. Владимирцовын төрсний 75 жилийн ойг (энэ 1959 оны 7-р сарын 20-нд), монголын, ард түмэн, түүний эрдэмтэн сэхээтэн нар бүх дэвшилт хүн төрөлхтний хамт элэгсэг дотно тэмдэглэж байна.

Шинжлэх ухааны нэрт зүтгэлтэн, эрдэмтэн Владимирцовын ариун нэр, гэгээн дурсгал, соёлт хүн төрөлхтний сэтгэл зүрхэнд үүрд дурсагдсаар байх болно.

## Академич Б. Я. Владимирцовын эрдэм шинжилгээний зохиолуудын цэс

1. «Дөрвөдийн ноёдын гарлын тухай домог», «Живая старина», 1909, XVIII жил, II-III дэвтэр. 35-37 дугаар тал.

2. 1908 онд Жамсраны Цэцээн, А. Д. Руднев нарын найруулан засаж хэвлүүлсэн «Монгол ардын утга зохиолын дээж» бичгийн «халх аялгуу» нэртэй I-р дэвтэрт зориулан бичсэн «Монгол ардын утга зохиолын шинэ бүтээл» гэдэг шүүмж. «Живая старина», 1909, XVIII жил, IV дэвтэр. 87-94-р тал.

3. «1908 оны зун Ховд хязгаарын дөрвөдүүдийн дотор ажилласан тухай Б. Владимирцовын тайлан», «Оросын Дундад, Дорнод Азийн судлалын хорооны мэдээ», СПб, 1909, 4-р сар, №9, 47-60-р тал.

4. «Ховдын дөрвөдүүдийн зан заншлын зарим зүйлээс», «Живая старина», 1909, XVIII жил, IV дэвтэр. 97-98-р тал.

5. «Монголчуудын зан заншлын зарим зүйлээс. I Архи. II. Тамхи», «Живая старина», 1910, XIX жил, I-II дэвтэр. 172-р тал.

6. «1908 оны зун Ховдын дөрвөдөөр явсан нь», «Оросын эзэн хааны газарзүйн нийгэмлэгийн мэдээ», XLVI, 1910, VIII-X дэвтэр. СПб, 1911, 323-355-р тал.

7. «Монгол хэлэн дэх турк хэлний зүйл», «Оросын эртний судлалын нийгэмлэгийн дорно дахины салбарын тэмдэглэл», СПб, 1911, XX боть, I-III дэвтэр. 153-184-р тал.

8. «Монголчуудын зохиосон, баруун хойд Монголын газрын зурагт хийсэн тайлбар», «Оросын эзэн хааны газарзүйн нийгэмлэгийн мэдээ», 1911, XL VII боть, VII-X дэвтэр; 491-494-р тал (зургийг ботийн эцэст хавсаргажээ).

9. «Ховд хязгаарын баяд нарын дотор ажилласан тухай . Владимирцовын тайлан», «Оросын Дундад, Дорнод Азийн судлалын хорооны мэдээ», СПб, 1912, II цуврал бичиг, № 11, 100-104-р тал.

10. «Монгол үлгэрийн бүртгэл», «Живая старина», 1912, XXI жил, Пг, 1914, 521-528-р тал.

11. «Монгол хэлний захирах төлөвт үгүйсгэх сул үгийн тухай», «Оросын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн мэдээ», 1916, 349-358-р тал. [«T'oung Pao»-д П. Пелльо тэмдэглэжээ. 1923, vol. XXII, p. 394]

12. «Турк угсаат хотон нар», «Оросын эртний судлалын нийгэмлэгийн дорно дахины салбарын тэмдэглэл», 1916, XXIII боть, 265-290-р тал. А. Н. Самойловичтай хамтран зохиожээ.

[«T'oung Pao»-д П. Пелльо тэмдэглэжээ. 1923, vol. XXII, p. 394].

13. «XIV зууны нэр нь үл мэдэгдэх гүрж түүхч монгол хэлний тухай үгүүлсэн нь», «Оросын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн мэдээ», 1917, 1487-1501-р тал. [«T'oung Pao»-д, П.Пелльо тэмдэглэжээ. 1923. vol. XXII, p. 394.]

14. «Оросын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Азийн музей профессор А. Д. Рудневийн шилжүүлсэн монгол гар бичмэл, модон барын зүйл», «Оросын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн мэдээ», 1918, 1549-1568-р тал. [«T'oung Pao»-д П. Пелльо тэмдэглэжээ. 1923. vol. XXII, p. 394.]

15. «Монгол, Төвөд дэх буддизм. Профессор Б. Я. Владимирцовын лекц», Гиб, 1919, 52-р тал.

16. «Төвөд фонд. Монгол фонд. Mongolica Polyglotta» «Азийн музей, 1818-1918. Товч танилцуулга»-эмхтгэл, Пг, 1920, 74-86-р тал.

17. «Монголын утга зохиол», «Дорно дахины утга зохиол»-эмхтгэл, 2-р дэвтэр, Пб, улсын хэвлэл, 1920, 90-115-р тал.

18. «Банзадандарын үлгэрийн монгол цоморлиг», Пг, 1921, 162-р тал. «Оросын Шинжлэх ухааны Хүрээлэнгийн тусгай хэвлэмэл зүйл, хүн судлалын музейн эмхтгэл»-ийн V ботийн тусгай хэвлэмэл зүйл, 401-552-р тал. С. Ф. Ольденбург шүүмж бичжээ, «Восток» 1922, 1-р дэвтэр. 113-114-р тал; [«T'oung Pao»-д П. Пелльо тэмдэглэжээ. 1923. vol. XXII, p. 395.]

19. «Миларайбын уянгын шүлгээс». Хоёр шүлгийг нь ор-

чуулж, удиртгал өгүүлэл бичиж хэвлүүлжээ, «Восток», 1922 1-р дэвтэр, 45-47-р тал.

20. «Чингис хаан» Берлин-Пб-М,З. И. Гржебиний хэвлэл, 1922. [Мөн номын тухай дор дурдсан шүүмж бий. Үүнд: В. В. Бартольд, «Восток», 1925,5-р дэвтэр, 251-256-р тал; Н. Козьмин «Жизнь Бурятии» 1925, №9-12, 171-172-р тал; Тэр номын орчуулгыг дурдвал: „Les grandes figures del' Orient“, Paris, 1926; The life of chingis Khan“, translated from the russian by prince“ D. S. Mirsky, London, 1930; “Çengiz Han“

(Çingis Han), çeviren Hasan Ali Ediz-Milli Egitim Bakanligi yayinlarindan, Bilim eserleri serisi, Rus dilim eserleri serisi: I. Istanbul, Milli Egitim Baslmevi, 1950.] эдгээр болно.

21. «Ид шидтэний тухай үлгэр», Монгол хэлнээс орчуулжээ. «Восток», 1923,2-р дэвтэр, 55-57-р тал.

22. [«Дорно дахины классикүүд» гэдэг номын тухай шүүмж.] «Восток», 1923,2-р дэвтэр, 137-141-р тал.

23. [«Энэтхэг үлгэр» гэдэг номын тухай шүүмж.] «Восток», 1923,2-р дэвтэр, 156-158-р тал.

24. [«Persian tales written down for the first time in the original kermani and bakhtia and translated by D. L. K. Lorimer and E. O. Lorimer with illustrations by Hilda ROBERTS» London, 1919. Дурдсан номын тухай шүүмж бичжээ.] «Восток», 1923, 2-р дэвтэр, 158-159-р тал.

25. [„Sino-iranica, Chinese contributions to the history of civilization in ancient Iran, with special reference to the history of cultivated plants and products by Berthold Laufer“. Curator of Anthropology Field museum of natural history. Publication 201 Anthropological series, vol. XV. №3. The Blackstone Expedition. Chicago, 1919. Дурдсан номын тухай шүүмж бичжээ.] «Восток», 1923, 2-р дэвтэр, 159-р тал.

26. L. Finot. Recherches sur la Littérature laothienne. "Bulletin de l' École Française de l' Extrême Orient". XVII, №3, 1917. Дурдсан номын тухай шүүмж бичжээ.] «Восток», 1923, 2-р дэвтэр, 159-р тал.

27. «Шидэт хүүр»-үлгэр. Уг үлгэрийг орчуулж, удиртгал үгүүлэл, тайлбар бичиж хэвлүүлжээ. Пб-М, улсын хэвлэл, 1923, [«T' oung Paо»-д П. Пелльо тэмдэглэжээ, 1923, vol. XXII, p. 395.]

28. [«Romances of old Japan. rendered into english from Japanese sources by Madame Yukio Ozaki» London. Дурдсан номын тухай шүүмж бичжээ.»] «Восток», 1923,2-р дэвтэр, 160-р тал.

29. «Төвөд жүжиг», «Восток», 1923,3-р дэвтэр, (97-107-р

тал.) [*\*Г' oung Pa*]-д П. Пелльо тэмдэглэжээ. 1923, vol. XXII p. 392.]

30. [*«Монгол орон, Амдо, сөнөсөн хар хот» гэдэг номын тухай шүүмж. 1907-1909 онд П. К. Козловын удирдсан, Оросыг газарзүйн нийгэмлэгийн уулархаг Азийн шинжилгээний анги, Пг-М., 1923.*] *«Восток», 1923, 3-р дэвтэр, 171-175-р тал.*

31. *«Монгол-ойрдын баатарлагийн тууль», уг туулийг орчуулж, удиртгал өгүүлэл, тайлбар бичжээ, Пб-М, улсын хэвлэл, 1923, 254-р тал.*

32. *«Баруун Монголын хутгалдмал хоёр хэлний тухай», «Яфетический сборник», II, Пг, 1923, 32-52-р тал.*

33. *«Угсаатны зүйн мэдээ» гэдэг номын тухай шүүмж. Уг номыг Оросын газар зүйн нийгэмлэгийн Дорнод Сибирийн салбар, «Красный бурят-монгол» сонины газрын хэвлэл 1923 оны 2-р сард хэвлэжээ. № 1-2. «Восток», 1923, 3-р дэвтэр, 182-р тал.*

34. *„The Folk-literature of Bengal, by Rai Saheb Dineschandra Seu. B. A. with a foreward by W. R. Gourlay, published by the University of Calcutta, 1920“ Дурдсан номын тухай шүүмж бичжээ]. «Восток», 1923, 3-р дэвтэр, 187-188-р тал.*

35. *«Монгол турк өвөг хэлний эгшиглэх ёсын зүйлээс», «Оросын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн илтгэлүүд», цуврал бичиг В, 1924, 33-35-р тал.*

36. *„,Dayan“-qaraq (Даян-хаан) гэдэг цолын тухай», «Оросын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн илтгэлүүд», цуврал бичиг В, 1924, 119-121-р тал.*

37. *«Монгол хэлний одоо цагт үйлт нэрийн үлдэгдэл», «Оросын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн илтгэлүүд», цуврал бичиг В, 1924, 55-56-р тал.*

38. *«Монгол бичгийн Теб-тенгри гэдэг нэрийн тухай дуртгал», «Оросын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн илтгэлүүд», цуврал бичиг В, 1924, 116-117-р тал.*

39. *«Марко Полын „Bevatini“», «Оросын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн илтгэлүүд», цуврал бичиг В, 1924, 118-р тал.*

40. *«И. Н. Березин-монголыг судлагч», «Оросын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Азийн музейн дэргэдэх дорно дахиныг судлагчдын зөвлөлийн тэмдэглэл», 1925, 1-р боть, 192-194-р тал.*

41. *«Монгол хэлэн дэх хэл зүйн хүйсийн үл мөр», «Оросын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн илтгэлүүд», цуврал бичиг В, 1925, 31-34-р тал.*

42. *«Mongolica I. Монгол хэл, Дундад Азийн энэтхэг»*

европ хэлнүүдийн харьцааны тухай», «Оросын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Азийн музейн дэргэдэх дорно дахиныг судлагчдын зөвлөлийн тэмдэгдэл», 1925, 1-р боть, 305-341-р тал.

[«Anthropos»-т А. Ункриг шүүмж бичжээ, 1926, vol. XXI Heft 3-4, S. 678.]

43. «Монгол газар зорчсон нь», «Вечерняя красная газета», 1925 оны 12-р сарын 4.

44. «Li-çihî gur-khan гэдэг Төвөд монгол толийн тухай», «СССР-ийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн илтгэлүүд», цуврал бичиг В, 1926, 27-30-р тал.

45. «Монгол ардын уран зохиолын дээж (Баруун хойд Монгол)», Л., 1926, 202-р тал.

Оршил, эх бичгийг галигчилжээ.

46. «Монгол Данжуур», «СССР-ийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн илтгэлүүд», цуврал бичиг В, 1926, 31-34-р тал.

47. «Монгол хэлний олон тооны нэг дагаварын тухай», «СССР-ийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн илтгэлүүд», цуврал бичиг В, 1926, 61-62-р тал.

(«T'oung Pao»-д П. Пелльо тэмдэглэжээ, 1931, vol. XXVIII, № 1-2, p. 229.)

48. «Халхын цогт тайжийн хадан дээрх бичээс», «СССР-ийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн мэдээ», 1926, XX боть, № 13-14, 1253-1280-р тал; XXI боть, № 3-4, 215-240-р тал.

49. «Өргөө ба Өргөө, хэнтийн орчин газраар угсаатны судлал, хэлний шинжлэлийн талаар судалгаа явуулсан нь» «Северная Монголия» гэдэг эмхтгэл, П, Л., СССР-ийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн хэвлэл, 1927, 1-42-р тал. [«T'oung Pao»-д П. Пелльо тэмдэглэжээ, 1931, vol. XXVIII, № 1-2, p. 228-229].

50. «Кастрен-монголыг судлагч», «М. А. Кастренийн нас барсны 75 жилийн ойн дурсгалд»-эмхтгэл, Л., СССР-ийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн хэвлэл, 1927, 87-92-р тал, мэдлэгийн түүхийн төлөв, П.) [«T'oung Pao»-д П. Пелльо тэмдэглэжээ, 1931, vol. XXVIII, № 1-2, p. 227-228.]

51. [Б. Лауферын «Монголын утга зохиолын төлөв» гэдэг номонд бичсэн оршил, Л., 1927, I-XXII тал.]

✓52. «Амарсанаагийн тухай монгол домог», «Восточные записки», 1-р боть, Л., 1927, 271-282-р тал. [«T'oung Pao»-д П. Пелльо шүүмж бичжээ, 1931, vol. XXVIII, № 3-5, P. 511-512.]

53. «Монгол бичгийн хэл, халх аялгууг харшуулсан зүйн бичиг. Удиртгал, авианзүй», Л., 1929. „A comparative grammar

of the literary mongolian and of the khalkha dialect. Intriduction and Phonetica" Leningrad, 1929. Дурдсан Номын хураангуй.

54. «Эртний туркийн «Otuken yls» гэдэг үгийн учир», «СССР-ийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн илтгэлүүд», цуврал бичиг В, 1929, 133-136-р тал. («T'oung Pao»-д П. Пелльо тэмдэглэжээ. 1931, vol. XXVIII, №1-2, р. 229-230.]

55. «Ил Аргун хааны бичигт байдаг нэг үгийн тухай», «СССР-ийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн илтгэлүүд», цуврал бичиг В, 1929, 152-р тал.

56. «Монгол хэлэн дээр хадгалагдаж үлдсэн Орхоны бичээсүүдийн газар зүйн нэрс», «СССР-ийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн илтгэлүүд», цуврал бичиг В, 1929, 169-174-р тал. («T'oung Pao»-д П. Пелльо тэмдэглэжээ. 1931, vol. XXVIII, р. 230.)

57. «Монголын покиг гэдэг үгийн учир», «СССР-ийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн илтгэлүүд», цуврал бичиг В, 1929, 287-288-р тал. («T'oung Pao»-д П. Пелльо тэмдэглэжээ, 1931, vol. XXVIII, №1-2, р. 229.]

58. «Эртний турк, шуучин монгол эх бичгийн тухай тэмдэглэл», «СССР-ийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн илтгэлүүд», цуврал бичиг В, 1929, 289-296-р тал.

(«T'oung Pao»-д П. Пелльо тэмдэглэжээ. 1931, vol. XXVIII, №1-2, р. 230-231).

59. «Bodhicaryavatara Cantideva. Шантидивын, Бодисад нарын явдалд орохуй. Чойжи-Одсэрийн монгол орчуулга». I. эх бичиг (Bibliotheca Buddhica XXVIII), Л., СССР-ийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн хэвлэл, 1929.

60. «Монголын Beki Begi цолын тухай», «СССР-ийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн илтгэлүүд», цуврал бичиг В, 1930, 163-167-р тал. («T'oung Pao»-д П. Пелльо тэмдэглэжээ. 1931, vol. XXVIII, №1-2, р. 231.]

61. «Эрдэнэ Зуугийн монгол бичээсийг уншихад зориулсан засвар», «СССР-ийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн илтгэлүүд», цуврал бичиг В, 1930, 186-188-р тал. («T'oung Pao»-д П. Пелльо тэмдэглэжээ, 1931, vol. XXVIII, №1-2, р. 231-232.)

62. «Tabun otog xafx-a-Халхын таван отгийн учир», «СССР-ийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн илтгэлүүд», цуврал бичиг В, 1930, 201-205-р тал. («T'oung Pao»-д П. Пелльо тэмдэглэжээ, 1931, vol. XXVIII, №1-2, р. 232.]

63. «Л. Я. Штернберг-хэлний шинжлэлч», «Л. Я. Штернбергийн дурсгалд»-эмхтгэл, Л., СССР-ийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн хэвлэл, 1930, 37-49-р тал. Мэдлэгийн түүхийн төлөв, VII). («T'oung Pao»-д П. Пелльо тэмдэглэжээ. 1932, vol. XXIX, №1-3, р. 257.]



64. «Монголын ongnijud гэдэг үг бол феодалын нэр томьёо бөгөөд аймгийн нэр мөн», «СССР-ийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн илтгэлүүд», цуврал бичиг В, 1930, 218-223-р тал. [«T'oung Pao»-д П. Пелльо тэмдэглэжээ, 1931, vol. XXVIII, p. 232.]

65. «Монгол хэлэн дэх араб үг». «Дорно дахиныг судлагчдын зөвлөлийн тэмдэглэл», 1930, V-р боть, 73-82-р тал. [«T'oung Pao»-д П. Пелльо тэмдэглэжээ, 1931, vol. XXVIII, № 3-5, p. 510-511.]

66. «Монгол бичгийн хэл. (Монгол, халимаг бичгийг латинчлахад зориулжээ)». «Дорно дахиныг судлах газрын тэмдэглэл», 1931, 1-р боть, 1-17-р тал.

67. «13-р зууны Монголын олон улсын цагаан толгой», «Дорно дахины бичиг, соёл», М., 1931, X дэвтэр, 32-42-р тал.

68. «Монголын нийгэмлэгийн байгуулал. Монголын нүүдлийн феодализм», Л., СССР-ийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн хэвлэл, 1934, XI, 223-р тал. (Энэ номын тухай А. Ю. Якубовскийн бичсэн, Б. Я. Владимирцовын «Монголын нийгэмлэгийн байгуулал» гэдэг ном ба Алтан Ордыг цаашид судлах судлалын ирээдүйн төлөв» гэсэн шүүмж бий, «Исторический сборник», 1936, V-р боть, 293-312-р тал; Дээрх номын орчуулгыг дурдвал: Mogollarin içtimai teşkilâti. Teroum. Abdulkadir inan, Ankara, 1944, 339S „Le régime social des mongols. Le féodalisme nomade“, Préf. par René Crousset, trad. par Michel Carsow, Paris, 1948, 291 p. («Publications du Musée «Guimet. Bibliotheque d'etubes», t. 52) эдгээр болно.



Хянагч Ө. Цэрэнпагма

---

Хэвлэлтэнд 1960 оны 1 дүгээр  
сарын 11-ний өдөр. Цаасны хэмжээ  
60×92. 1/16. Хэвлэлийн хуудас 1,25.

Хэвлэсэн тоо 2000

Б—00459.

Зах. № 7

---

Эрдэм шинжилгээний хэвлэх  
үйлдвэр. Лениний гудамж. 5

### Анхааруулга

Хэвлэлийн бололцоогүйгээс зарим гал-  
 лиг үсэг, түүний цэг уртатгал зэрэг янз  
 бүрийн таних тэмдгийг зохих ёсоор тэм-  
 дэглэж чадаагүйг анхааран уншина уу!

### ЗАЛРУУХГА

Ш. Барайшир. Монголч эрдэмтэн Б. Я  
 Владимирцов

Хуудас №	Мөр	Ташаарсан нь	Залруулсан нь
6	22	evlev-in	evler
7	10	re	yre
8	17	үсгийн	үгсийн
8	37	биээ	билээ
8	39	элдэр	элдэв
13	7	Ortient	Orient
13	24	hhistory of	history of
14	21	«тоcmок»	«Восток»
16	36	xafx	xalx